

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ГАДНА ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ҮЙЛЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

PURSUIT OF REGULATION AND MONGOLIAN CRIMINAL CODE FOR CRIME COMMITTED IN OVERSEES



A.АМАРБАТ

ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад

AMARBAT A.

Senior investigator at the Organized crime combating division of the Criminal Police Department, National Police Agency, Police captain

Товч агуулга: Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байсан үндэслэл, журмыг судлан, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх зорилгоор 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгээс хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиудыг харьцуулах байдлаар энэ өгүүллийг бичлээ.

Abstract: Mongolia, the court death penalty notes, where the main goal is to study and compare the criminal procedure codes applied during the investigation of the crimes committed outside of territory of Mongolia/on penalizing the criminals who committed crime outside of territory of Mongolia through the years starting early twenties. In particular, the main purpose was to determine the investigation tactics, the development of the criminal procedure codes, the basis of the crime filing, the development of this certain type of crime analyzing.

Түлхүүр үгс: Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Шүүх цаазын бичиг, Эрүүгийн хууль, Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйл.

Key words: Republic of Mongolia. Justice documentary, Criminal code, crime committed overseas. Criminal code of Mongolia, article 14.

Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл журмыг нэг мөр тодорхой болгох, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, Эрүүгийн хуулийн ерөнхий 14 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад шалтгааны улмаас түдгэлзүүлсэн байгаа хэргүүдийг эцэслэн шийдвэрлэх зорилгоор

судалгааны ажлаа хийж байгаа билээ.

“Түүхээ мэдэхгүй хүн ойд төөрсөн сармагчин лугаа адил” хэмээн Монгол түмэн маань ярьдагтай нэгэн адил судлаач миний бие судалж буй сэдвийнхээ талаар, түүний үүсэл хөгжил, хэрхэн өөрчлөгдөн хувьсаж байсан талаар мэдэхгүйгээр энэ сэдвийг судалж цаашид шаардагдах хуулийн гаргалгаа, өөрчлөлтийг тодорхойлох боломжгүй юм.

Сэдвийн хүрээнд түүхэн уламжлалаас



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ЦААЗЫН
БИЧИГ



нь эхлэн уг сэдвийг судалж одоо тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх, цаашдын чиг хандлагыг нарийвчлан судлах нь онолын болон практик ач холбогдолтой.

Зөвхөн Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь өрөөсгөл ойлголт бөгөөд Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулиар зохих хариуцлагыг хүлээлгэх, гадаад улсад Монгол Улсын эрх ашгийг хөндсөн гэмт хэрэг гарсан тохиолдолд тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх, олон улсын гэрээнд нэгдэн орсон нэгдмэл үзэл бодолтой улс орнуудынхаа эрх ашгийг Эрүүгийн хуулиараа хамгаалж чаддаг байх нь Монгол Улсын тусгаар тогтносон улс гэдгээ бататгах, үндэсний аюулгүй байдлаа хамгаалах нэгэн чухал асуудал болоод байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн үүсэл, хөгжил дээр үндэслэн сэдвийн түүхэн уламжлалын үечлэлийг тогтоох нь: Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж буюу Эрүүгийн эрх зүйн үүсэл хөгжлийн талаар судлаач бүр өөр өөрийнхөөрөө үзэл бодлоо илэрхийлдэг. Эдгээр нь ч гэсэн үнэнд нийцсэн, түүхэн эх сурвалжууд дээр суурилсан байдаг. Ихэнх судлаачид Эрүүгийн хууль тогтоомжийг үндсэн 8 үе шатад хуваан авч үздэг. Үүнд:

1. Монголын эртний улсуудын эрүүгийн шинжтэй хууль тогтоомжууд

2. Их Монгол Улсын эрүүгийн шинжтэй хууль тогтоомжууд

3. Их Монгол Улсын бутралын үеийн эрүүгийн шинжтэй хууль тогтоомжууд

4. Манжийн ноёрхлын үеийн эрүүгийн шинжтэй хууль тогтоомжууд

5. Богд хаант Монгол Улсын эрүүгийн шинжтэй хууль тогтоомжууд

6. Ардын хувьсгалын дараах буюу 1926 он хүртэлх эрүүгийн шинжтэй хууль тогтоомжууд

7. 1926 оны Шүүх цаазын бичиг батлагдан мөрдөгдөж эхэлснээс 1990 он хүртэлх эрүүгийн хууль тогтоомжууд

8. Ардчилсан Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж (одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа)

Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн

хэрээр шинэ төрлийн гэмт хэргүүд үйлдэгдэж байдгаас харахад гэмт хэрэг нийгмийн нэгэн өвчин гэлтэй. Тэгвэл өвчин туссан үед анагаах, анагаасны дараа түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдагтай нэгэн адилаар гэмт хэргийг шалгаж шийдвэрлээд шинэ тутам гарч болзошгүй хэргүүдийн талаар урьдчилсан прогноз хийж, шинэ төрлийн гэмт хэргүүдийг хуульчилснаар гэмт хэрэгтэй тэмцэж чадна.

Энэ л тодорхой нэгэн зарчим дээр тулгуурлан Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж үеийн үед, цагийн цагт хувьсан өөрчлөгдөж хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийгэмдээ гэмт хэрэгтэнд зохих хариуцлагыг нь хүлээлгэж, хохирсон иргэдийн эрхийг хамгаалан Эрүүгийн хууль гэдэг мөн чанараа хадгалан өдийг хүрсэн байдаг.

Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Монгол Улсын эрүүгийн хууль үйлчлэх үндэслэл журмын талаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангид тусгагдсан байдаг учир анхны ерөнхий болон тусгай анги бүхий одоогийн эрүүгийн хуулийн үндэс суурь болсон хуулиас эхлэн сэдвийн түүхэн хөгжлийн талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

1926, 1929, 1934 онуудад БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг" нийт 3 удаа шинээр болон шинэчлэгдэн батлагдаж тухайн хугацаандаа хүчин төгөлдөр үйлчилж байсан ба 1942 оноос эхлэн БНМАУ-ын Эрүүгийн хууль нэртэйгээр батлагдан гарч үүнээс хойш 1961, 1986, 2002 онуудад шинэчлэгдэн батлагдаж байсан.

Иймд сэдвийн түүхэн үечлэлийг:

1. 1926-1941 оны БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдэд гадаад улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хууль хэрхэн үйлчлэх талаар тусгагдсан байдал;

2. 1942 оноос хойших БНМАУ-ын болон Монгол Улсын Эрүүгийн хуулиудад Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хууль үйлчлэх талаар тусгагдсан байдал хэмээн ангилан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

1926-1941 оны БНМАУ-ын шүүх



цаазын бичгүүдэд тусгагдсан хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам:

1926 оны БНМАУ-ын шүүх цаазын бичиг

1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн БНМАУ-ын Нэгдүгээр хурлаар БНМАУ-ын шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 7 бүлэг 40 зүйлтэйгээр баталж 1 дүгээр бүлэгт нь энэхүү шүүх цаазын бичгийг журамлан дагаж явуулах хэмжээ хязгаарыг тусгаж өгсөн. Үүний дараа 1926 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн БНМАУ-ын шүүх цаазын бичгийн тусгай ангид 8-31 дүгээр бүлэг 40-227 дугаар зүйлийг багтаан баталснаар анхны бүрэн хэмжээний буюу ерөнхий анги, тусгай анги бүхий эрүүгийн эрх зүйн эх сурвалж /Эрүүгийн хууль/ бүрэлдсэн. "БНМАУ-ын шүүх цаазын бичиг"-ийг боловсруулахад ЗХУ-ын Эрүүгийн хуулийг гол үзэл баримтлалаа болгосон байдаг.¹

БНМАУ-ын шүүх цаазын бичгийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд: Энэхүү шүүх цаазын бичгийг зарласан өдрөөс хойш гарсан аливаа гэмт явдал, үйлдсэн хэрэгт журамлан дагаж шийтгэвээс зохино. Үүнд тайлбарлах нь: Аливаа цааз хуульд заасан эл явдлыг гэмт хэрэгт тооцвоос зохино.

2 дугаар зүйлд Энэхүү цаазын бичгийг зарласан өдрөөс урьд өдүүлсэн хэргүүдийг тэр цагийн хуулийг дагаж таслан тогтоох боловч хэрэв тэрхүү хэргүүдийн дотор энэ цаазын бичигт ялтайд тооцох буюу эсвэл ялыг хөнгөлөх зүйл буй аваас энэ хуулийг баримтлан шийтгэвээс зохино.

3 дугаар зүйлд Энэхүү шүүх цаазын бичгийг БНМАУ-н харьяат, хязгаарын дотор бүхий дотоод гадаадын иргэнд хэнд ч атугай халдсан хамаг эрүүгийн хэргийг шийтгэхэд журамлан дагаваас зохино. Гагцхүү гадаад улсын элчин ба консул үл оролцоно.

4 дүгээр зүйлд Тусгай тогтоол ба олон улсын хооронд гэрээ бичгүүдийн

дотор дурдсан онц зүйлүүдэд энэхүү шүүх цаазын бичгийг хэрэглэж үл болно хэмээн заасан байна.

Үүнээс үзэхэд анхны Эрүүгийн хуулийн бүтэц бүхий Шүүх цаазын бичиг нь зөвхөн БНМАУ-ын харьяат, хязгаарын дотор буюу Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах газарт гэмт хэрэг үйлдсэн БНМАУ-ын болон гадаад улсын иргэнд хамаарахаар заасан байна. Шүүх цаазын бичигт "элчин ба консул үл оролцоно" хэмээн дипломат эрх ямба бүхий этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй хэмээн заасан байгаа нь тухайн үед Монгол улсад гадны орнуудын нөлөөлөл ямар их байсныг харуулж байна.

Анхны Шүүх цаазын бичигт учир дутагдалтай зүйл их байсан нь нийгэмд гарч буй гэмт хэргээс илэрхий байсан тул 1929 онд шинэчлэн найруулсан байдаг.

1929 оны БНМАУ-ын шүүх цаазын бичиг

1929 оны "Шүүх цаазын бичиг" нь 1926 оны шүүх цаазын бичгийн систем, зохион байгуулалтад үндсэн өөрчлөлт оруулаагүй боловч хуулийг дахин боловсруулахдаа түүний хэм хэмжээг ойлгож хэрэглэхэд хялбар болгож сайжруулсан нь хуулийг бүхэлд нь шинээр батлах шалтгаан болсон байна.²

1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар хурлаар БНМАУ-ын шүүх цаазын бичиг ерөнхий, тусгай анги нийт 30 бүлэг 227 зүйлтэй батлагдсан ба Нэгдүгээр бүлэгт энэхүү шүүх цаазын бичгийг зарлан дагаж явуулах хэмжээ хязгаарыг тусгаж өгсөн.

БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 1 дүгээр зүйлд Энэхүү шүүх цаазын бичгийг зарласан өдрөөс хойш гарсан аливаа гэмт явдал үйлдсэн хэрэгт журамлан дагаж шийтгэвээс зохимой. Үүнд тайлбарлах нь: Энэхүү цаазын бичигт заасан аливаа явдлыг гэмт хэрэгт тооцвоос зохимой.

2 дугаар зүйлд Аливаа хэргийг таслан

¹ Доржийн Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998. 6 дугаар тал

² Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 86 дугаар тал /дам иш татав/.



шийтгэх дор уул хэргүүдийг өдүүлсэн цаг дор дагаж буй хууль зүйлүүдийг баримтлаваас зохих ба хэрэв тэрхүү хэргүүдийн дотор энэхүү цаазын бичиг дор ялтайд үл тооцох буюу эсвэл ялыг хөнгөтгөх зүйл буй аваас энэхүү хуулийг баримтлан шийтгэвээс зохимой. Тайлбарлах нь: Энэхүү зүйл дор заасан хэрэг өдүүлсэн цаг дор дагаж буй хууль зүйлүүд хэмээсэн нь гагцхүү Ардын засгийг байгуулснаас хойш зохион зарласан аливаа хуулиуд болмой.

3 дугаар зүйлд Энэхүү шүүх цаазын бичгийг БНМАУ-ын харьяат хязгаарын дотор бүхий дотоод гадаадын хүмүүн иргэн хэн дор ч атугай халдсан хамаг эрүүгийн хэргийг шийтгэх дор журамлан дагаваас зохимой. Гагцхүү гадаад улсын элчин ба консулууд үл оролцмой.

4 дүгээр зүйлд Бусад улс лугаа байгуулсан гэрээ бичгүүд ба мөн гадаад лугаа харилцах нийтийн дүрэм ба зарим дор холбогдох тусгай тогтоолын дотор дурьдсан хэрэг зүйлүүд дор энэхүү шүүх цаазын бичгийг үл хэлэлцмой гэж тусгасан байна.

Үүнээс харахад өмнөх хуулийн үзэл баримтлал өөрчлөгдсөн зүйлгүй, Шүүх цаазын бичиг үйлчлэх нутаг дэвсгэр, хамрах этгээд хэвийн байсан ба ойлгомжтой болгох зорилгоор үг хэллэгийг бага зэрэг өөрчилсөн нь харагдаж байна. Мөн “гадаад лугаа харилцах нийтийн дүрэм ба зарим дор холбогдох тусгай тогтоолын дотор энэхүү шүүх цаазын бичгийг үл хэлэлцмой” гэж заасан байгаа нь БНМАУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрт дурьдсан зүйлийг Шүүх цаазын бичгээр шийдэж болохгүй, уг гэрээ хэлэлцээрийг голлох хэм хэмжээ болгоно гэдгийг илэрхийлсэн байна.

Тусгаар тогтнолоо зарлаад удаагүй байгаа улс оронд гадаад улс орнуудын нөлөөлөл, хавчлага шахалт ямар их байсан нь үүнээс илэрхий харагдаж байна.

1929 оны Шүүх цаазын бичиг тухайн үедээ маш олон дэвшилтэд талуудыг багтуусан хэм хэмжээ байсан боловч гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хэрхэх талаар

дурдаагүй байлаа.

1934 оны БНМАУ-ын шүүх цаазын бичиг

1934 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн хурал, мөн оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 17 дугаар хурлаар БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг батлан мөрдсөнөөр 1929 оны Шүүх цаазын бичгийн ерөнхий анги хүчингүй болсон. Энэ удаад зөвхөн ерөнхий ангийг баталсан ба тусгай ангид ямар нэг өөрчлөлт оруулаагүй.

“Шүүх цаазын бичиг зарласан нь Ардын хувьсгалт засаг ба улс хийгээд тогтоосон хэм хэмжээнд харшлах олон нийтийн дор аюул бүхий хэргүүдээс хамгаалах зорилготой бөгөөд тийнхүү хамгаалахдаа уул үйлдсэн хүмүүст энэ шүүх цааз бичигт заасан ёсоор шийтгэх ялуудыг хэрэглэмой” гэж анх удаа Эрүүгийн хуулийн зорилтыг тодорхойлсон. Мөн шинээр баталсан ерөнхий ангийн 2 дугаар бүлэгт Шүүх цаазын бичгийг журамлан дагаж явуулах хэм хэмжээ, хязгаарын талаар тусгасан.

БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 2 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд

1.БНМАУ-ын харьяат хязгаарын дотор бүхий дотоод гадаадын хүн иргэн нь хэн нь атугай өдүүлэн хамаг гэмт хэргийг шийтгэхэд журамлан дагаваас зохино. Гагцхүү улсын Засгийн газраас бусад улсуудтай байгуулсан тусгай гэрээний ёсоор халдаж үл болох эрхийг эдлэх этгээдэд үл хамаарна.

2.Тус улсын харьяат хүн, иргэнээс гэмт хэргийг гадаадад үйлдэж, тус улсын хязгаар дотор баригдсан ахул түүний бүх гэмт хэргийг шийтгэхэд мөн журамлан дагавал зохино.хэмээн тусгаснаар эрүүгийн хууль тогтоомжид анх удаа Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнд эрүүгийн хариуцлагыг оногдуулахдаа Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална гэсэн зохицуулалтыг оруулж өгсөн нь одоогийн Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийн түүхэн хөгжлийн эхлэл байсан юм.

Анх удаа хуулинд ийм зохицуулалт оруулсан нь дэвшилттэй боловч тухайн



үед мэдээж дутагдалтай тал байсныг үгүйсгэхгүй. Учир нь зөвхөн гадаад улсад гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнд хариуцлага хүлээлгэхээр тусгасан байсан.

1942-2002 оны БНМАУ-ын болон монгол улсын эрүүгийн хуулиудад тусгагдсан хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам:

1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль

1940 оны үед Монгол Улсын нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарснаас шалтгаалан тухайн оны 06 дугаар сард шинэ үндсэн хуулиа баталсан. Үүнээс шалтгаалан салбар хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах зайлшгүй шаардлага гарсан ба 1942 оны 1 дүгээр сарын 17-нд Улсын 25 дугаар бага хурлаар Шүүх цаазын бичгийг "БНМАУ-ын Эрүүгийн хууль" нэртэйгээр батлан гаргасан нь Эрүүгийн эрх зүйн түүхэнд мөн томоохон өөрчлөлт болсон нь одоог хүртэл өөрчлөгдөөгүй байна.

Энэ хуулиар манай улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гадаадын харьяат хүмүүс энэхүү хуулиар шийтгэгдэх болсон.³ БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэгт Эрүүгийн хуулийг журамлан дагаж хэрэглэх хэмжээ хязгаарын талаар тусгасан.

БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд БНМАУ-ын газар дэвсгэр дээр ба мөн БНМАУ-ын хязгаарын гадна үйлдсэн боловч тус улсын хязгаар дотор илэрсэн нийтэд аюул бүхий гэмт хэрэг үйлдсэн БНМАУ-ын харьяат хэн нэгэн ард иргэдийг энэхүү хуулийг журамлан дагаж шийтгэнэ.

3 дугаар зүйлд БНМАУ-ын газар дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын харьяат хүмүүс нь энэхүү хуулийн ёсоор шийтгэгдэнэ.

4 дүгээр зүйлд БНМАУ-ын засгийн газраас бусад улсуудтай байгуулсан тусгай гэрээний ёсоор халдаж үл болох эрхийг эдэлж бүхий гадаадын харьяат

нарт эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал тохиолдвол тухай бүрт дипломат журмаар шийдвэрлэнэ хэмээн тусгасан байна.

Энэ хуулийн давуу тал нь Эрүүгийн хууль гэдэг нэртэй болсон, гадаадын харьяат хүнд хариуцлага хүлээлгэдэг болсон зэргээс гадна "халдаж үл болох эрхийг эдэлж бүхий гадаадын харьяат нарт" хэмээн тусгаж өгснөөр дипломат эрх ямба бүхий гадаад улсын иргэдэд хариуцлага хүлээлгэх анхны тогтолцоог бүрдүүлсэн. Гэвч гадаад улсад үйлдэгдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх асуудалд шинэчлэл гэхээр зүйл гарч ирсэнгүй.

1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль

1942 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсон бөгөөд уг хуулиар гэмт хэрэгт тооцогдож байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинжээ алдсан гэдэг үндэслэлээр эрүүгийн хуулиас хасч, нийгэмд аюултай үзэгдлийг шинээр гэмт хэрэгт тооцож эрүүгийн хуулинд нэмэлт оруулсан.⁴

1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр БНМАУ-ын Ардын их хурлын 2 дугаар чуулганаар Эрүүгийн хуулийг шинэчлэн баталж 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн бөгөөд уг хуулийн 1 дүгээр бүлэгт Эрүүгийн хуулийг журамлан дагаж мөрдөх хэмжээ хязгаарыг зааж өгсөн.

БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд

А. БНМАУ-ын Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн БНМАУ-ын иргэд ба тус улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэд, мөн аль ч улсын иргэн биш хүмүүст энэхүү хуулийг хэрэглэнэ. Гадаад улсын Дипломат төлөөлөгч ба мөн дагаж шийтгүүлж буй хууль, олон улсын гэрээ хэлэлцээр ёсоор БНМАУ-ын шүүхээр эрүүгийн хэрэгт шийтгэгдэхгүй бусад хүмүүст тус улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдвэл тухай бүрд нь дипломат шугамаар шийдвэрлэж байна.

³ Суурийн Жанцан. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал шинэчлэлийн асуудал. УБ., 2007. 68 дугаар тал.

⁴ Доржийн Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшх Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998. 149 дугаар тал.



Б. БНМАУ-ын иргэд ба аль ч улсын иргэн биш хүмүүсээс тус улсын хязгаарын гадна үйлдсэн гэмт хэрэг, БНМАУ-ын хил хязгаарын дотор илэрвэл тэдэнд энэхүү хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэж шийтгэнэ. Хэрэв эдгээр хүмүүс үйлдсэн гэмт хэрэгтээ хил хязгаарын гадна шийтгэгдсэн бол шүүх тэдэнд оногдсон ялыг энэхүү хуулийн ёсоор хөнгөлөх буюу бүр мөсөн хэлтрүүлж болно. БНМАУ-ын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу шийтгүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгөхгүй.

В.БНМАУ-ын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэдийг БНМАУ-ын Эрүүгийн хуулиар шийтгэх тухай олон улсын хэлэлцээрт заасан байвал тэдэнд энэхүү хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Г. Хэргийн гэм буруутай ба ял шийтгэлийг уг гэмт хэрэг үйлдэх үеийн дагаж шийтгүүлэн байсан хуулиар тогтооно гэж заасан байна.

Үүнээс үзэхэд 1961 онд Монгол улс Нэгдсэн үндэсний байгууллагад гишүүн орноор элссэн нь дэлхийн ихэнх улс дагаж мөрдөж байсан олон улсын гэрээ, конвенцод нэгдэх, хүний эрхийг дээдлэх зэрэг асуудлуудыг хурцаар тавихаар нөхцөл байдлыг бий болгосон байна. Эрүүгийн 3 дугаар зүйлд хуулийг журамлан хэрэглэх хэмжээ хязгаарыг нарийвчлан зааснаас гадна. “БНМАУ-ын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу шийтгүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгөхгүй.” хэмээн анх удаа иргэнээ хамгаалсан, иргэний эрхийг хамгаалсан заалт оруулснаас илэрхий харагдаж байна.

Мөн БНМАУ-ын хязгаарын гадна гэмт хэрэг үйлдсэн “аль ч улсын иргэн биш хүн” хэмээн харьяалалгүй хүнийг тодорхойлон түүнд хариуцлага хүлээлгэхээр заасан нь давуу тал болсноос гадна гэмт хэрэг үйлдсэн газартаа буюу гадаад улсад ял шийтгүүлсэн тохиолдолд БНМАУ-ын эрүүгийн хуулиар оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх талаар дурдаж өгсөн нь маш том дэвшилт болсон.

1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль

1986 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн БНМАУ-ын ардын их хурлаар шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийг баталсан ба уг хуулийн 1 дүгээр бүлэгт Эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээдийн талаар тусгасан.

БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд

1. БНМАУ-ын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдэд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

2. Гадаад улсын дипломат төлөөлөгчид болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу БНМАУ-ын шүүхэд эрүүгийн хэргийн талаар харьяалагдахгүй бусад иргэн БНМАУ-ын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

3. Тус улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн БНМАУ-ын иргэн, харьяалалгүй этгээд БНМАУ-ын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдсан буюу шүүхэд шилжсэн бол тэдэнд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Эдгээр хүмүүс үйлдсэн гэмт хэрэгтээ хилийн гадна ял эдэлсэн бол шүүх тэдэнд оногдсон ялыг энэ хуулийн дагуу хөнгөрүүлж буюу гэм буруутай этгээдийг ял эдлэхээс бүрэн чөлөөлж болно. Хэрэв БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүйд тооцож болно.

4. БНМАУ-ын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэнд БНМАУ-ын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

5. БНМАУ-ын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу ял шийтгүүлэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй гэж заасан.

Үүнээс үзэхэд 1961 оны хуулинд орсон дэвшилтэт хэсгүүд улам төгөлдөржиж бусдад ойлгомжтой, хэрэгцээ шаардлагыг хангасан байдалтай 1986 оны хуулинд тусгагдсан байна.

Мөн “Хэрэв БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүйд тооцож болно.” хэмээн заасан нь иргэнийхээ



эрхийг хамгаалсан заалт болсноос гадна энэ зүйлд анх удаа гадаад улсад гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэнд олон улсын гэрээг үндэслэн Монгол Улсын Эрүүгийн хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар тусгасан.

Анхлан батлан гаргаж байсан хуулиудад гадаадын иргэнд хариуцлага хүлээлгэх талаар дурдаж ч чадахгүй байсан Монголын хуулинд гадаад улсын иргэнд хариуцлага хүлээлгэх талаар заасан байгаа нь Монгол Улсын тусгаар тогтносон, биеэ даасан байдал хэрхэн батажсан болохыг харуулсан нэгэн томоохон илрэл болсон юм.

2002 оны Монгол Улсын Эрүүгийн хууль

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь ... манай оронд 1980-1990-ээд онд бий болсон улс төрийн нөхцөл байдал, хөгжил тэмцлийн үйл явц, үр дүнг тусган бэхжүүлсэн Монголын түүхийн шинэхэн үеийн хууль зүйн гол баримт бичиг мөн.⁵

1992 онд БНМАУ ардчилсан Монгол Улс болж шинэ үеийн Үндсэн хуулиа баталсан. Үүнтэй холбоотойгоор салбар хуулиудад томоохон өөрчлөлт шинэчлэл хийх шаардлагатай болсон боловч Эрүүгийн хуулийг шинээр батлахгүйгээр ихээхэн өөрчлөлт оруулан, шинэчлэл хийсэн. Хичнээн шинэчлэл хийж өөрчилсөн боловч Эрүүгийн хуулийн үндсэн зарчмууд нь нийгмийн шаардлагад нийцэхгүй болсон учир эрүүгийн хуулийг 2002 онд шинэчлэн найруулж баталсан.

2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Монгол Улсын их хурлын чуулганы хурлаар Монгол Улсын Эрүүгийн хуулийг баталж 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн нь одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Монгол Улсын эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэгт эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацаа, нутаг дэвсгэр, хамаарах этгээдийн талаар тусгасан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлгийн 14 дүгээр

зүйлд Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хууль үйлчлэх үндэслэл, журмын талаар заасан.

1.Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн хэрэгтээ ял шийтгүүлээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.Энэ хуулийн 14.1-д заасан этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ гадаад улсад ял шийтгүүлсэн бол Монгол Улсын шүүх түүнд оногдуулсан ялыг энэ хуулийн дагуу хөнгөрүүлэх буюу ялаас чөлөөлж болно. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүйд тооцож болно.

3.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн албан хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

4.Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

5.Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тус улсын хилийн гадна Монгол Улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлээгүй бол Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно хэмээн тусгасан байна.

Үүнээс үзэхэд өмнөх хуульд тусгагдсан байсан давуу талуудыг бүрэн дурдсанаас гадна Орчин үед шинээр тулгарч буй нөхцөл байдал буюу гадаад улсад энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчин, цэргийн алба хаагч нар оролцож эхэлсэнтэй холбоотойгоор гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалтыг оруулсан.

Мөн Монгол Улсын хилийн гадна Монгол Улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлээгүй

⁵ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал / тэргүүн дэвтэр/. УБ., 2002. 46-р тал.

этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар хуулийн заалт оруулсан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ямар өндөрт тавигддаг, гадаад улс, хилийн чанадад ч гэсэн өөрийн улс орны эрх ашгийг хамгаалах боломжтой болсныг илтгэж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Анхны Шүүх цаазын бичигт дурдагдаж ч байгаагүй гадаад улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Монгол Улсын эрүүгийн хууль үйлчлэх үндэслэл журам хэрхэн хөгжиж нэг үг, нэг өгүүлбэрийн хэмжээтэй байснаас Эрүүгийн хуулийн 5 заалт болтлоо өргөжиж ирсэн нь юутай холбоотой вэ гэсэн эргэцүүлэл төрлөө.

Энэ бол нийгмийн хэрэгцээ шаардлага, нийгмийн захиалгаар бүрэлдэн бий болсон хуулийн хэрэгцээ шаардлага бүхий зүйл, заалт юм. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг хэн олж мэдэрч, түүнд тохирсон хуулийн санаачлагыг гаргах ёстой вэ гэвэл мэдээж хууль зүйн салбарын судлаачид бид билээ.

Тэгвэл 2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулинд тусгагдсан дээрх 5 заалт өдөөгийн бидний амьдарч байгаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадаж байна уу, энэ асуултанд хариу авах нь миний хойшид хийх судалгааны ажлын эрхэм зорилгын нэг нь юм байна гэдгийг мэдлээ.

Иймээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэдийн талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж түүнийг нэг бүрчлэн бүртгэж гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг судлан прогноз хийж байх;
- Монгол Улсын хилийн гадна Монгол Улсын эрх ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдол бүрийг бүртгэж, шаардлагатай тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байх;
- Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд холбогдуулан Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд заасныг журамлан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа хэрэг материалуудыг эцэслэн шийдвэрлэж, Монгол Улсын эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах;
- Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд нэмэлт өөрчлөлт оруулан зарим хэсгийг тодорхой болгож, хуулийн заалтыг ашиглах, хэрэгжүүлэхэд хялбар, дөхөм болгох зэрэг болно.

НОМ ЗҮЙ

1. Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшх Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998.
2. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал шинэчлэлийн асуудал. УБ., 2007.
3. Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011.
4. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал /тэргүүн дэвтэр/. УБ., 2002.
5. <http://www.legalinfo.mn>

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хурандаа Д.Мягмарцэрэн**